



“МОНГОЛ АЛТ”ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 18-аадар

№ 01.

Дархан уул аймаг

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Компанийн тухай хуулийн 46.5, 46.6 дахь заалт, Монгол-Алт ХХК-ийн дүрмийн 17.1, 17.5 дахь зааль, ТҮЗ-ийн 2023 оны 02 сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ:

- Хуралд оролцогч гишүүдийн 100 хувийн саналаар ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтсугай.
- Ногдол ашиг хуваарилахгүй тогтсон үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захирал М.Цолмонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

М.ЦОЛМОН



**“МОНГОЛ АЛТ”ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН  
ТЭМДЭГЛЭЛ**

2023 оны 02 сарын 18 өдөр

№ 01

Дархан уул аймаг

**Ногдол ашиг хуваарилах эсэх тухай**

“Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурал 2023 оны 2 сарын 18-ны өдрийн 11<sup>00</sup> цагт гүйцэтгэх захирлын өрөөнд эхлэв.

Хуралд Компанийн ТУЗ-ийн дарга Б.Саруул АНУ-д ажилаж байгаа тул биечлэн оролцох боломжгүйгээ утсаар илэрхийлж, хурал даргалах гишүүнээр компанийн дүрмийн 8.18 дэх заалтыг үндэслэн гишүүн М.Цолмонг томилж байгаагаа илэрхийлсэн болно.

Гишүүн М.Оюун, хараат бус гишүүн Л.Базарсад, О.Лувсаншаав нар оролцов. Мөн Гишүүн Ж.Мөнхтөр, Л.Амарсанаа, А.Болортuya, хараат бус гишүүн С.Дорждэрэм нар хэлэлцэх асуудал, шийдвэрийн төсөлтэй эчнээ танилцаж, дэмжиж буйгаа утсаар илэрхийлсэн. ТУЗ-ийн хурлын ирц хуулийн дагуу бүрдсэнийг М.Цолмон танилцуулав.

Ингээд хурлыг нээж хурал даргалагч, гишүүн М.Цолмон хэлэлцэх асуудлыг танилцуулав. Үүнд:

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46.5, 46.6 дэхь заалт, компанийн дүрмийн 17.1, 17.5 дэхь заалтын дагуу ТУЗ ногдол ашиг олгох, эс олгох талаар шийдвэрээ гаргаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх ёстой.

Хурал даргалагч: - Миний бие компанийн гүйцэтгэх захирлын хувьд ногдол ашиг олгох, эс олгох талаар мэдээлэл өгье.

Компани нь 1995 оноос эхлэн жил болгон ногдол ашгаа тогтмол олгож ирсэн. 2020, 2021, 2022 онуудад цар тахалтай холбоотой санхүүгийн байдал хүнд байгаа тул энэ жил ногдол ашиг хуваарилах боломжгүй байна.

Хурал даргалагч: - Компанийн өрөнхий нягтлан бодогч Ж.Мягмаа 2022 оны үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн үр дүнгийн талаар тайлан танилцуулна.

Хурал даргалагч: Та бүхэн тайлантай танилцлаа. Хэлэлцэж буй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Санал хүсэлт байвал хэлж болно.

ТУЗ-ийн хараат бус гишүүн О.Лувсаншаав: - Дэмжиж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүн Л.Базарсад: Гүйцэтгэх захирлын саналыг дэмжиж байна.

ТУЗ-ийн гишүүн М.Оюун: Дэмжиж байна.

ТҮЗ-ийн хараат бус гишүүн О.Лувсаншарав: - Дэмжиж байна. Цар тахлын дараа компанийн үйл ажиллагаа жигдэрхэд хугацаа шаардлагатай.

Хурал даргалагч: - Миний хувьд дэмжиж байгаа. Та бүхэнд өөр санал байвал хэлж болно. Байхгүй бол хурлаас доорхи тогтоолыг гаргахаар шийдвэрлэж байна. Та бүхэнд танилцуульяа. Үүнд:

#### Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46.5, 46.6 дахь заалт, "Монгол алт"ХК-ийн дүрмийн 17.1, 17.5 дэхь заалт, ТҮЗ-ийн 2023 оны 2 сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

- Хуралд оролцогч гишүүдийн 100 хувийн саналаар ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.
- Ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн үндэслэлээ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг гүйцэтгэх захидал М.Цолмонд үүрэг болгосугай.

Хурал даргалагч: Та бүхэн хурлаас гарах тогтоолын төсөлтэй танилцлаа. ТҮЗ-ийн гишүүд та бүхэнд ажлын амжилт, эрүүл энхийг хүсье. Энэ удаагийн ээлжит хурал өндөрлөж байна. Сар шинэдээ сайхан шинэлээрэй!

Шийдвэрийг зөвшөөрсөн:

М.Цолмон

Ж.Мөнхтөр

М.Оюун

О.Лувсаншарав

Л.Базарсад

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

С.Бат-Эрдэнэ